

## ОРЧИН ҮЕИЙН ФИЛОСОФИ ДАХЬ ДОМГИЙН ОНТОЛОГИ АСУУДАЛД

С.Соёлмаа (ШУА-ийн ФСЭХ-ийн ЭША)  
МУИС. НШУС.

Философийн тэнхмийн докторант

*Түлхүүр үгс: Домог, мөнхийн давтамж, зан үйл, хамтын төсөөлөл, бэлгэ тэмдэг, бүтэц, гайхамшиг, шидэт үг, бүхэл ертөнц, гэртээ байхуй*

Бид энэ өгүүлэлдээ домог (орос хэлний миф, англи хэлний mythos) гэсэн ойлголтыг орчин үеийн<sup>1</sup> философичид хэрхэн авч үздэгийг тоймлон авч үзээд, улмаар домгийн суурь онтологи, мөн чанарыг тодорхойлоход оршино.

XIX зууны төгсгөл XX зууны эхэнд философичид иррационалист үзэлтэй холбоотойгоор домогт ихээхэн анхаарлаа хандуулах болсон байна. Романтикууд болон Шеллингийн дараа Шопенгаур домог, зөн совинг оюун ухаантай харьцуулан илүү их утга санаагаар баяжуулж байлаа. Ницше домгийг түүхд эсрэгцүүлэн тавьж домог нь соёлыг сэргээх зайлшгүй нөхцөл хэмээн үзсэн байна. Тэрээр «Хөгжмийн оюун санаанаас урган гарах эмгэнэлт жүжгийн үүсэл<sup>2</sup>» хэмээх зохиолдоо домгийн тогтвортой, гоо сайхан апполлон эхлэлийн цаана байгалийн, тогтворгүй, зан үйл-домгийн балар эртний дионис эхлэл нуугдаж байдаг гэсэн байна. Ницшегийн домгийн тухай үзэл нь домгийн зан үйлийн утгыг онцолж анхаарсан явдал болсон юм. Ницше домгийг ийнхүү үзсэн нь домгийн орчин үеийн тайлбарын үндсийг тавьсан байх үндэстэй юм.

Экзистенциалист философич Камю «Сизифийн тухай домог» бүтээлдээ мөнхийн давтамжийн тухай санаагаа хурц эмгэнэлт домгийн хэлбэрээр өөрийн философийн үзэлдээ гаргаж ирсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Камю эртний Грекийн домгийн эпизодыг<sup>3</sup> ашиглаж өөрийн экзистенциалист философийн үзлээ гаргаж тавьсан юм. Тэрээр бүтээлийнхээ эхэнд «Энэ удаагийн бичвэртээ манай зуунд хаа сайгүй гаарч буй абсурдын мэдрэмжийн тухай ярих болно. Үнэнийг хэлэхэд, манай үеийнхэнд төдийлөн танил болж дэлгэрээгүй абсурдын философийн тухай биш, харин мэдрэмжийн тухай л ярих юм...» гэсэн байна. Сизиф бол Эртний Грекийн домогт Эол ба Энаретейн эоланчуудын хааны хүү. Камю Сизифийн тухай хэд хэдэн домгийг сэргээн өгүүлж буй ч, Сизифийг зальт шунахай этгээд гэж үздэг уламжлалыг орхиж байна. Амин хувиа хичээгч уг дээрэмчин замын явуулын хүмүүсийг том хадаар дарж алсны учир Аидэд шийтгэгджээ. Ийм маягаар Камю домгийг философидолтын, танин мэдэхүйн арга зүй болгосон юм.

XX зууны эхээс эхэлсэн домгийн сэргэлтийн үе эхэлж Европын соёлын янз бүрийн хүрээг хамарсан үйл явц болжээ. Энэ үед домгийн тухай дараах байр суурь, үзэл санаа бүрэлдэн тогтоод байсан юм. Нэгдүгээрт, домог бол орчин үеийн нийгэмд ч гэсэн практик үүрэг гүйцэтгэдэг мөнхийн амьд эхлэл; хоёрдугаарт, домгийг мөнхийн давтамжийн тухай

1. Энд «Орчин үеийн» гэдэг ойлголтыг XX зууны, сонгодог бус гэсэн утгаар авсан болно.

2. Ницше Ф. Сочинения в 2 т. Т. 1. Литературные памятники-М.: Мысль, 1990. С. 47-156.

3. Эпизод (грек. ἐπεισόδιος — оруулга): 1. Жижиг хэмжээний, тусгай үйл явдал; 2. Бие даасан өгүүлэмж, утга бүхий, уран зохиол, кино бүтээлийн гол үйл явдлын бүрдэл хэсэг. Энэ нь зохиолын гол сэдэвтэй холбоотой хэдий ч тусгай өгүүлэмж, төгсгөлтэй.

үзэлтэй холбон тайлбарлаж, домог дахь зан үйлийн шинжийг онцолсон; гуравдугаарт, домог ба зан үйлийг үзэл суртал ба сэтгэл зүйтэй, урлагтай адилтган үзсэн зэрэг болно.

XX зууны домог нь соёлын онол ба социологийн шинжлэх ухаанд гол ойлголтуудын нэг болсон гэж үзэх үндэстэй. Угсаатан зүй нь хамгийн эртний шинжтэй домгийг судлах чиглэлтэй болжээ. Хэрэв сонгодог угсаатан судлал домгийг байгалийн хатуу ширүүн хүчинд автагдсан зэрлэг хүмүүсийн хорвоо ертөнцийг тайлбарлах шинжлэх ухаанч бус арга зам гэж үзэж байсан бол домогт хандах шинэ хандлага XX зууны эхэнд бүрэлдэн тогтжээ. Боас, Фрейзер, Дюркгейм нарын домгийн тухай үзэл нь Малиновскийн зан үйлийн функционализм, Леви-Брюлын балар эртний «хамтын төсөөлөл»-ийн логизмын өмнөх үеийн тухай онол, Юнгийн сэтгэл зүйн «символизм», Леви-Строссын «бүтэц» шинжлэлийн эхлэлийг тавьсан юм.

XX зууны Америкийн антропологич Франц Боас соёл-угсаатан судлаач Генри Морганы даяаршил хувьслын онолыг үгүйсгэдэг. Тэрээр тусгаар угсаатан соёлын бүс нутгийг судлахыг чухалчилсан байна. Боас балар эртний сэтгэлгээний логик хангалтгүй шинжийг уламжлалт үзэл санааны шинжээр нь тайлбарласан бөгөөд энэ сэтгэлгээ нь орчин үеийн Европын иргэншлийн хүний сэтгэлгээтэй механизмаараа адил болох тухай өгүүлдэг. Мөн тэрээр балар эртний оюун санаа нь олон эх үүсвэртэй, сэтгэл хөдлөл ихтэй, бэлгэ тэмдгэн шинжтэй гэж үздэг байна. Боас домгийн тайлбарлах үүргийг үгүйсгээгүй бөгөөд домог, зан заншил, зан үйл нь ухамсаргүй, аяндаа тогтох үйл явц хэмээн үзжээ.

Ж.Ж.Фрэзер (1854-1941) Английн антропологийн дэг сургуулийн төлөөлөгч бөгөөд Тэйлорын дэвшүүлсэн анимизмын онолыг гүйцээж ид шидийн үйлийн (магия) тухай үзлээ боловсруулжээ. Тэрээр илбэ домьг хүний сэтгэлгээний эртний түвшин дэхь амьдчилсан онгодод бус, харин эзэн биегүй хүчинд чиглэдэг хэмээн үзжээ. Фрэзер тахил өргөл, тотемизм, хуанли хөтлөх зан үйлийг илбэ домтой холбон тайлбарласан байдаг. Тэйлороос ялгаатай нь Фрэзер домгийг орчлон ертөнцийг тайлбарлах ухамсарт оролдлогын шинжээр бус, харин үлдэж хоцорсон зан үйлийн хуулбар гэдэг үүднээс тайлбарлажээ. Фрэзер домгийн зан үйлийн талыг онцолсноороо төдийгүй “үхэж үрэгдсэн”, “ариуссан” бурхдуудын хуанлийн зан үйл, домгийн судалгаагаараа (ялангуяа «Алтан мөчир» гэсэн номондоо эмхтгэсэн) домог зүйд томоохон хувь нэмэр оруулсан юм. Түүний гол санаа нь ид шидийн үйл ба орчин үеийн шинжлэх ухааны хооронд тодорхой зааг хязгаар байгааг үгүйсгэхэд оршдог. Ид шидийн үйл бол шинжлэх ухааны суларсан хэлбэр, тэр шинжлэх ухааны адилаар байгалийн ерөнхий хуулийг хүлээн зөвшөөрч, гадаад ертөнцөд нөлөөлөх гэсэн зорилгыг бас агуулдаг. Хөгжлийн нийтлэг объектив хуулиар оршин байдаг юмс нь домгийн сэтгэлгээний бүтцэд үндсээрээ эсрэгцэх аналитик сэтгэлгээг шаарддаг. Гэвч домгийн сэтгэлгээ бол гүн гүнзгий сэтгэл хөдлөлийн шинжтэй, хүний сайхан болон муу муухай гэсэн хоёр туйлт хүчтэй хийсэн эцэс төгсгөлгүй тэмцэл юм. Домгийн сэтгэлгээний хувьд байгальд «саармаг объект» гэж үгүй ажээ.

Бронислав Малиновский (1884-1942) бол Английн угсаатан судлаач, угсаатан судлал дахь функционализмыг үндэслэгч юм. Тэрээр домгийг зан үйлийн рефлекс үйлдэл бус, харин домог ба зан үйлийн ёслол нь балар эртний соёлын тогтолцоон дахь үгийн ба үйлдлийн, «онолын» ба «практик» талыг харгалзан илэрхийлдэг гэсэн байна. Малиновский Тробриандын арлуудын отог омгийнхны судалгааны үр дүн болох «Балар эртнийнхний сэтгэл зүй дэхь домог» хэмээх бүтээлдээ домгийн тухай үндсэн үзэл санаагаа боловсруулжээ. Мөн балар эртний нийгэм дэх домог нь хүн орчлон ертөнцийг шинжлэх ухааны ба шинжлэх ухааны бус байдлаар танин мэдэх арга хэрэгсэл бус, түүхээс өмнөх далд бодит байдалд хандсан, овгийн соёлын уламжлалыг хадгалсан цэвэр практик үүргийг гүйцэтгэдэг гэж үзсэн байна. Домог нь санаа бодлыг эмхтгэн найруулж, ёс суртахууныг бэхжүүлж, зан байдлын тодорхой дүрэм журмыг санал болгож, зан үйлийг баталгаажуулж, нийгмийн харилцааны тогтсон дүрэм журмыг зөвтгөдөг. Малиновский домгийг прагматик үүргийнх нь үүднээс үнэлэн дүгнэж, домог нь хувь хүн ба нийгмийн сайн сайхны төлөө хямралт асуудлыг шийдвэрлэх хэрэгсэл, эдийн засаг болон нийгмийн хүчин

зүйлийн зохицлыг дэмжих арга хэрэгсэл хэмээн үзжээ. Малиновскийн үзлээр домог бол энгийн хүүрнэл, ам дамжсан хууч яриа бус, харин аман байдлаар «ариун бичвэр» хэлбэрээр, хүн болон ертөнцийн хувь заяанд нөлөөлдөг, үндэстэн ард түмний амсаж туулж өнгөрүүлсэн, нэгэн бодит байдал юм. Домгийн бодит байдал нь түүхээс өмнөх үйл явдалд хамаарах бөгөөд зан үйл, түүний шид домын үйлээр дамжин үндэстэн ард түмний бодит байдал болж үлддэг.

Домгийн тухай ритуализм ба функционализмын үзлээр домог бол сургаал, номлол итгэл үнэмлэлийн тогтолцоо бус, дүр төсөөллийн гэхээсээ илүү ихэнхдээ үйлдлийн шинжтэй юм. Зан үйл бол номлолоос илүү анхдагч шинжтэй. Энэ талаар П.С.Гуревич «... бидэнд домгийн ойлголтын элементийг ялгаж салгах аз завшаан тохиолдлоо гэж бодоход бид мөн чанараараа хөдөлгөөнт шинжтэй шидэт домгийн тогтвортой зарчмыг ойлгож чадахгүй»<sup>4</sup> гэсэн байна.

Домог зүйн орчин үеийн онолыг хөгжүүлсэн Л.Леви-Брюль (1857-1939), Э.Дюркгейм (1858-1917) нарыг францын социологийн дэг сургуулийг үндэслэгчид гэж үздэг. Английн антропологийн дэг сургуулиас ялгаатай нь францын социологийн дэг сургууль нь домгийн хамтын сэтгэлзүй, социумын үүднээс авч үзсэн байдаг. Энэ утгаараа францын социологийн дэг сургуулийнхны гол нэр томьёо нь «хамтын төсөөлөл» юм. Дюркгейм «Шашны амьдралын энгийн хэлбэрүүд. Австралийн тотем тогтолцоо» хэмээх бүтээлдээ шашин, шидэт домог, зан үйлийн эртний хэлбэрийн үүслийн асуудалд шинэ хандлагыг эрж хайсан юм. Дюркгейм шашныг домогос салган авч үзээгүй бөгөөд шашныг домогт эсрэгцүүлж, нийгмийн бодит байдлыг илэрхийлсэн хамтын төсөөлөлтэй адилтгасан байна. Тэрээр шашин, домгийн төсөөллийн үүргийг бус, харин үүсэл гарвалд гол анхаарлаа хандуулдаг бөгөөд ялангуяа нийгмийн амьдралын өрнөх хэлбэр болох зан үйлийг онцлон авч үздэг бөгөөд нийгмийн бүлэг нь зан үйлийн тусламжтайгаар өөрийгөө баталгаажуулдаг гэсэн байна.

Дюркгейм шашин ба домог зүйн энгийн хэлбэрийг эрж хайх үйл явцдаа байгалийн хүчин эсвэл эзэн савдагт бус, харин тотем шүтлэгт илүү анхаарлаа хандуулдаг. Түүний үзлээр онгон шүтээний зарчим нь шүтээн болж буй ургамал, амьтны мэдрэгдэх олон янзын хэлбэр байдлаар, уран сэтгэмжээр төсөөлөгддөг отог (буюу төрөл) юм. Мөн тотем домог зүй нь төрөл овгийн зохион байгуулалтыг загварчилж, түүнийг дэмжих үүрэг гүйцэтгэдэг.

Мөн Дюркгейм шашин домгийн сэтгэлгээн дэх зүйрлэл, бэлгэ тэмдгийн үүргийг авч үзсэн нь ихээхэн сонирхол татахуйц юм. Тэрээр шашны мэдрэмжийн үндсэн элемент нь бэлгэ тэмдэг бөгөөд үүнийг зөвхөн ёс журам талаас нь бус, нийгмийн бодит байдлын илэрхийлэл юм хэмээн үзсэн байна. Тиймээс нийгмийн амьдрал нь бүхий л хүрээндээ, түүхийн бүхий л цаг хугацаанд зөвхөн өргөн хүрээ бүхий символизмын ачаар л боломжтой байсаар ирсэн байна. Нийгмийн шаардлагын үүднээс янз бүрийн ойлголтыг нэгтгэх нь ертөнцийн анхдагч тайлбарыг өгч байдаг ба үүний дараа л философи, шинжлэх ухаанд зам нээгдэнэ гэсэн байна.

Дюркгеймын домгийн сэтгэлгээний онцлогийн талаарх үзэл санаа Л.Леви-Брюль, К.Леви-Стросс нарын онол, концепод нөлөөлсөн байдаг. Л.Леви-Брюльн балар эртний сэтгэлгээний онцлогийн талаарх онол, концепц нь домог зүйн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан байдаг. Домог бол балар эртний хүмүүсийн танин мэдэх хүслээ хангах хэрэгсэл болдог, шинжлэх ухаанаас өмнөх гэнэн рациональ танин мэдэхүй хэмээх XIX зууны сонгодог угсаатан зүйн үзэл санааг Леви-Брюльн онол эрс үгүйсгэсэн юм.

Түүний үзлээр нууц далдын элементүүд нь домгийн хамгийн үнэ цэнэтэй зүйл нь юм. Шууд үл мэдрэгдэх хамаарал бүхий чанар (тухайлбал, соёлын баатар эсвэл хагас хүн, хагас амьтны мөн чанар бүхий домгийн уг удам) домогт төлөөлөн оршдог. Леви-Брюль домгийг хүрээлэн буй орчныг тайлбарлах арга хэрэгсэл гэж үзэхээс зайлсхийж, харин Малиновскийн адилаар нийгмийн бүлгийн эв санааны нэгдлийг дэмжих арга зам хэмээн үздэг. Энэ тухай П.С.Гуревич «К.Леви-Брюль домгийн сэтгэлгээг хамгийн гүн гүнзгий байдлаар ойлгосон бөгөөд түүний

4. П.С.Гуревич. Философия культуры. М., 2000. с. 95

хувьд домгийн сэтгэлгээ бол «логикийг урьдач» шинжтэй, түүнд бидний логикий хууль, эсрэг тэсрэгийн хууль тохирохгүй. Хэрэв энд ямар нэг шалтгаалцлын тухай ярьж болж байвал, энэ бол логик эсвэл эмпирик бус, харин далд хүчний шалтгаалцал юм» гэсэн байна.

Германы философич Эрнст Кассирер (1874-1945) 1925 онд хэвлүүлсэн «Бэлгэдлийн хэлбэрийн философи» хэмээх гурван боть бүтээлийнхээ хоёрдугаар боть болох «Домгийн сэтгэлгээ» хэмээх бүтээлдээ XX зууны эхний арван жилийн угсаатан зүйн ололт амжилт, үр дүнг өргөн хэрэглэсэн байдаг. Кассирер Прейсийн адилаар домог дахь зан үйлийг онцолдог бөгөөд бэлэр эртний шашин нь ид шидийн хүчний тухай үл ялгах зөн совингоос эхлэлтэй гэж үздэг. Түүний үзлээр домог зүй нь мэдрэмж, сэтгэл хөдлөлийн бэлгэдэлт объективчлалын онцгой арга, хэмжүүр бүхий, хэл, урлагийн адилаар, соёлын биет даасан бэлгэ тэмдгийн хэлбэр юм. Домог нь орчлон ертөнцийг загварчлах арга, үйл ажиллагааны шинжийг нэгтгэсэн хаалттай бэлгэ тэмдгийн тогтолцоо юм. Кассирер домгийг бодит байдлыг танин мэдэх, бүтээлчээр эмхлэн цэгцлэх хэлбэр гэдэг талаас нь шинжилснээс гадна түүнд зөн зовин, сэтгэл хөдлөлийн эхлэл байгааг үнэлж чадсан юм. Кассирер домгийн сэтгэлгээний онцлогийг бодит ба санаалаг, юмс ба дүр, биет ба шинж, «эхлэл» ба зарчмын ялгаагүй гэж үздэг. Энд ямар нэг харилцаа хоорондоо нийлдэггүй, харин адилтгагддаг; «хууль дүрэм»-ийн оронд тодорхой адилтгасан дүр; хэсэг нь үүргээрээ бүхэлтэйгээ адил; бүхий л сансар огторгуй нь нэг л загвартай байх бөгөөд гэгээрэл ба мунхаг хэмээх эсрэгцлээр илэрхийлэгддэг. Үүнээс л Кассирерын авч үзсэн орон, цаг, тооны тухай төсөөлөл урган гардаг. Амьдралын нэгдмэл байдлын тухай домгийн мэдрэмж нь бодит байдалд хамгийн ойр байх хүрээнд хандсан хүний хандлага; хүний тусгаар бүлэг амьтны төрөл зүйлтэй шид домоор нэгдсэн нэгдэлд (тотем шүтлэгт) илэрдэг.

Кассирерын символик онол нь домгийн морфологийн<sup>5</sup> судалгааны ирээдүйг нээсэн явдал болсон юм. Түүний үзлээр домгийн орон зайн байр суурь, чиглэл бүхэн ариун, бузрыг ялгахын төлөөх онцгой акцент байдаг. Хэдийгээр домгийн орон зай нь агуулгаараа геометрийнхтэй харьцуулшгүй хэдий ч хэлбэр, зохион байгуулалтаараа геометрийнхтэй тодорхой хэмжээгээр адил юм. Домгийн орон зай нь цэвэр математикийн функциональ орон зайнаас өөр, бүтцэт шинжтэй. Цаг хугацааны хувьд домог нь гарал үүсэл, цаг хугацааны амьдрал, үйлдэл, түүх, хүүрнэлийг илэрхийлж байдаг. Домгийн өнгөрсөн цаг нь юмсын шалтгаан буюу «яагаад» нь болдог. Ийм байдлаар цаг хугацаа нь оюун санааны зөвтгөх анхны оригиналь хэлбэр юм. Домгийн анхдагч цаг хугацаа нь орон зайн харилцааны илэрхийллийн тусламжтайгаар бодит, эмпирик цаг хугацаа болон хувирдаг. Биологийн цаг хугацааны домгийн мэдрэмж нь сансрын цаг хугацааны зөн мэдрэмжээс урьдач шинжтэй байдаг. Цаг хугацааны домгийн хэлбэр нь ариун ба бузрын хуваарилалтаас хамаардаг гэсэн байна.

Домгийн тухай Кассирерын философийн бас нэг гол хэсэг нь домгийн ухамсрын субъектыг тодорхойлж, домгийг амьдралын хэлбэр хэмээн авч үзсэн явдал юм. Бие хүн, «би», сэтгэл хэмээх нэр томьёо нь гадаад ба дотоод ертөнцийн харилцаа хамаарал, тэдний хоорондын зуучлалын үр дүнд, зорилго ба хүслийн хоорондын холбоос бий болсон цагт аажмаар ялгарч гарч ирдэг. Сэтгэл эхнээсээ биетэй адил шинжтэй байдаг бол аажмаар ёс суртахууны ухамсрын субъект болж (биологиос ёс суртахуунд шилжих хөдөлгөөн) хувирдаг. Домог дахь хүний хил хязгаар нь нэлээд урсгал шинжтэй бөгөөд үйлдэл нь ид шидээр холбогдсон тийм л бодит байдлын элементтэй нэгдэн нийлдэг. Амьд зүйлтэй нэгдмэл гэдэг бүдэг бадаг мэдрэмж нь амьтан ба ургамалын нэгж төрөлтөй нэгдмэл гэсэн нэлээд онцгой мэдрэмж болж хувирдаг. Кассирерын үзлээр хүний цэвэр ухамсар удаан төлөвшдөг. Энэ нь гадаад байдлаараа бурхдыг хүмүүнжүүлэх, баатруудыг бурханжуулахаар илэрдэг. Домгийн байгаль нь объектод хийсэн идэвхтэй үйл ажиллагааны үр дүн, хөдөлмөр, багаж хэрэгслийн ид шидийн бус хэрэглээнд тогтсон агуулгатай болдог. Бие хүний ухамсарлахуй нь хүн ертөнцийг бүтээж, улмаар энэ

5. Морфологи (грек. *Morphos* - хэлбэр)-1. Амьтан ба ургамалын бие организмн бүтэц хэлбэрийг судлах шинжлэх ухааны нэхдэл. 2. Хэл шинжлэлд үгийн дүрэм зүйн утгын илэрхийлэл болон бүтцийг судлах дүрэм зүйн салбар.

ертөнцдөө өөрөө өөрийгөө харуулахыг хэлнэ. Энд зөвхөн материаллаг ертөнцийн тухай бус, мөн символ буюу бэлгэ тэмдгийн ертөнцийг хэлж байгаа юм. Түүний үзлээр домог нь тийм ч ил тод ухамсарлагдаж амжаагүй дүрт ертөнцөд илэрдэг. Бэлгэ тэмдгэн илэрхийллийн өөрийнх нь мөн чанар нь дүр ба утгын зөрчил байдаг. **Домгийн сэтгэлгээний хэлбэр нь бүхий л бодит байдлыг зүйрлэл болгон хувиргадаг.** Кассирерын онолоор зөвхөн урлагт л дүр ба утгын зөрчил арилдаг бөгөөд энд дүрийг яг өөрийнхөөр нь хүлээж авдаг. Кассирер хожуу үеийн бүтээлүүддээ («Хүний тухай туршлага», «Улс төрийн домог») домгийн нийгэм, сэтгэл зүйн аль аль талыг нь харгалзан үзсэн байдаг. Тэрээр домог нь үхэл хэмээх баримтыг үгүйсгэж; амьдралын нэгдмэл, тасралгүй шинжийг онцолдог гэсэн байдаг. Оросын домог судлаачид болох Е.Мелетинский, С.Ю.Неклюдов нар домог судлах символик аргыг Сибирь болон Төв Азийн аман зохиол, домгийн судалгаанд хэрэглэсэн юм.

Домгийн бэлгэ тэмдгийн тайлбарыг үргэлжлүүлсэн нь сэтгэгч бол Сюзанн Лангер юм. Мөн тэрээр өөрийгөө А.Н.Уайтхедын залгамжлагч хэмээн зарласан байдаг. Сюзанн Лангер «Шинэ философи» (1951) хэмээх бүтээлийнхээ «Амьдралын бэлгэ тэмдэг. Домгийн үндэс» хэмээх бүлэгт **домгийн бэлгэ тэмдгийг үлгэртэй харьцуулахад уран сэтгэмжийн хөгжлөөрөө дээгүүр төвшин гэх байдлаар авч үздэг.** Уран сэтгэмжийн анхны хэлбэр нь «үүдний субъектив, хэсэг үзэгдэл» байдаг. Энд ямар нэг бэлгэ тэмдэг болсон бодьгал үйлдэж, субъектив илэрхийллийн үйл явц явагдаж байдаг. Үлгэр, хууч ярианд хувь бэлгэ тэмдгүүд илүү түгээмэл бэлгэ тэмдгүүдээр (араатан амьтан, сүнс, шулмас гэх мэт) солигддог. Үлгэр, хууч ярианаас амьтад онгод сүнстэй таарснаар шидэт үлгэр бий болж улмаар бич, матар, хүн иддэг махчин, үхэгсэд нарыг гүнж, луу, хар санаатай хаан, ноён орлох болдог. Үлгэр бол хувь бодьгал, түүний хүслийг биелүүлэхэд чиглэсэн субъектив шинжтэй байдаг учир түүний гол баатрууд нь бурхад, гэгээнтнүүд бус, харин хүмүүс байдаг. Харин уран сэтгэмжит хүүрнэлийн дээд хэлбэр болох домогт л бодьгалд гай зовлон тохиолдож, аз жаргалаас салах үйл явц болж улмаар хорвоо ертөнцийн үнэнийг мэдэж, ертөнцийн дүр зураг өгөгдөж эцсийн дүндээ хүний бус хүчний улмаас бий болсон хүний хүслийн бодит, жам ёсны зөрчлийг хүлээн зөвшөөрөхөд хүрдэг. **Түүний үзлээр домог нь нийгмийн төдийгүй сансар огторгуйн хүчний (тэнгэрийн биетүүд; жилийн дөрвөн улирал, өдөр шөнийн солигдол) харилцааг өөртөө багтаадаг. Хэрэв үлгэрт хүн хэмээх гол баатар гайхамшигийн оронд оршдог бол харин домогт бурханлаг гол баатар бодит ертөнцөд оршдог.** Домгийн шилжсэн хэлбэр нь соёлын баатруудын тухай домог үг байдаг. Лангерын үзлээр хувь хүний бодлын тодорхой бус хэлбэржээгүй дүрүүд нь нийтийн уламжлалын тусламжтайгаар тодорхой хэлбэрийг олдог байна. Тэрээр энэхүү номныхоо өөр нэг бүлэгт домгийг хөгжимтэй харьцуулсан байдаг бөгөөд хөгжмийг «дотоод амьдралын домог» хэмээн нэрлэсэн байна. Домог, хөгжим хоёрт бүтээгдэхүүн ба үйл явцын ялгарал байдаггүй; таамаглаж буй утга санаа нь зөвхөн амьдралын янз бүрийн мэдрэмжийг дагалдаж гарч ирсэн утгуудаар хязгаарлагддаггүй.

Германы сэтгэл судлаач Вильгельм Вундт «Ард түмнүүдийн сэтгэл судлал», «Домог ба шашин» хэмээх бүтээлүүддээ Английн антропологиин дэг сургуулийнхны үзэл санаатай нэлээд ойр байдлаар анимист буюу амьдчилах онол үзэл баримтлалыг хөгжүүлсэн юм. Ялангуяа домгийн гарал үүслийг аффект буюу сэтгэлийн хөдлөл, зүүдний үзэгдэлтэй холбон тайлбарласан байдаг.

Сэтгэц задаргааны онолыг үндэслэгч Зигмунд Фрейдin онолын үндэс нь «эдипын цогц» хэмээн нэрлэгдсэн далд ухамсарт байх, эсрэг хүйснийхээ ойр дотно хүнийг сонирхох сексийн дур хүсэл юм. Фрейд «Онгон шүтээн ба хорио цээр» хэмээх бүтээлдээ дээр дурдсан «эдипын цогц»-д нийгэм, урлаг, ёс суртахуун, шашны эхлэл тавигджээ хэмээн үздэг. К.Г.Юнг домгийг сэтгэц дэх ухамсаргүй эхлэлтэй холбож, домгийг сэтгэцийн хамтын ухамсаргүй эхлэлтэй холбон тайлбарласан байна. Фрейдээс ялгаатай нь Юнг далд ухамсрын хоёр үеийг ялган үзсэн. Үүнд, сэтгэцийн янз бүрийн өвчин эмгэгийг агуулж байдаг, хувийн туршлагатай

холбоо бүхий гадаргын үе; хамтын ухамсаргүйн гүнзгий түвшний үе хамаарна. Энэхүү далд ухамсарын гүн гүнзгий түвшин нь домог маягийн эртний хэв шинж болох архетипыг агуулдаг байна. Түүнчлэн хамтын далд ухамсар нь эзгүй объектив зүйл бөгөөд болгууд нь анхны байдалдаа биеэ даан оршин байдаг хэмээн үзжээ. Өөрөөр хэлбэл далд ухамсар нь домгийн сэтгэлгээний адил нийтийг хамарсан зүйл гэж ойлгоход болно. Эртний хэв шинжүүд (архетипы) болон тэдгээрт тохирох домгийн нэгжүүд нь бэлгэдлийн сэтгэлгээний категори бөгөөд тэднийг ангилж тайлбарлах нь адил төстөй хэлнүүдийн хоорондын орчуулга төдий зүйл болох юм. Юнгийн үзлээр аливаа юмыг бэлгэднэ гэдэг нь нэг талаас адилтгах чанар, нөгөө талаас үйлдүүлэх чанар гэсэн хоёр утгатай. Юнг сэтгэл зүйн зөрчлийг шийдвэрлэх тухай, мөн ухамсарт үйлдэл ба зөн бэлгийн үйлдэл хоёрын хамаарлыг авч үздэг. Юнгийн онол домог зүйн тэмдэг зүйн онолуудтай нэлээд ойролцоо юм. Түүний домгийн философийн гол бүтээлүүд нь «Би ба ухамсаргүйн харилцаа», «Сэтгэл судлал ба шашин», «Ухамсаргүйн дүрүүд», «Оюун санааны бэлгэдэл зүй», «Ухамсарын үндсийн тухайд» зэрэг болно.

Юнгийн чиглэлийн гол сэтгэгч болох Ш.Бодуэн нь «Баатрын гайхамшигт ялалт. Агуу туульс дахь баатарлаг домгийн тухай сэтгэц задаргааны шинжлэл» хэмээх бүтээлдээ «Гильгамеш», «Илиад», «Рамаяна» зэрэг туулийн дурсгалыг баатарлаг домгийн нэг хэлбэр хэмээн үзээд эдгээрийн үндэс нь үхэл, хоёр дахь төрөлтийн тухай санаа байдаг гэжээ. Домгийн баатарлаг тэмцэл нь «хоёр дахь үхэл»-ийн бэлгэ тэмдэг юм. Мөн Юнгийн чиглэлийн, домгийн философи шинжлэлд томоохон хувь нэмэр оруулсан судлаачид бол Ж.Кэмпбелл, М.Элиаде нар юм. Ж.Кэмпбелл «Мянган нүүртэй баатар», «Бурхдын баг» хэмээх бүтээлүүдээ олон ард түмэн, бүхий л үеийн домгийг сэтгэц задаргааны онолын үүднээс ялангуяа Юнгийн онолын үүднээс тайлбарлахыг оролдсон юм. Тэрээр домгийг биологийн үүднээс хүний мэдрэлийн системийн үйл ажиллагаатай холбон тайлбарлажээ.

Элиаде нь «Мөнхийн давтамжийн домог», «Домгийн аспектүүд» зэрэг нэг сэдэвт бүтээлдээ австраличуудын домог ба зан үйл, йог, бөө мөргөл, шашны онолоо боловсруулжээ. Тэрээр домгийг зан үйлтэй холбож үздэг. Элиаде нь Малиновскийн балар эртний домгийн онтологийн тухай үзлийг улам гүнзгийрүүлэн домогт зөвхөн бодит байдал бус, мөн хүний оршин ахуйн үнэ цэнэ байх бөгөөд энэ нь домгийн ариун гэгээн цаг хугацаа, өвөг дээдсийн «эртний хэв шинжит» үйлээр тодорхойлогдоно. Тэрээр зан үйлийн үүргийн үүднээс домгийг ангилахдаа домгийн ухамсрыг орчин үежүүлж, түүнд түүхэн цаг хугацааг үгүйсгэх шинжээс гадна цаг хугацааны эргэлт буцалтгүй шинж, түүх, «дорд» цаг хугацаа зэрэгтэй тэмцэх зорилгот тэмцэл байдаг гэсэн байна. Түүхийн эргэлт буцалтгүй шинж ба «шинэ зүйл»-д татагдах сонирхол нь хүний амьдралын саяхны нээлт гэж Элиаде үзжээ. Зан үйлд домгийн «цэвэр» ариун цаг хугацаа сэргээгдэж, мөн үүний зэрэгцээ өнөө цаг үгүй болдог гэж үзжээ.

Домгийн тухай чухал концепцыг Францын угсаатан судлаач, философич Клод Леви-Стросс боловсруулсан юм. Домгийн бүтэц шинжлэлийн үндсийг тавьсан чиглэл бол Кассирер, Юнг нарын «бэлгэдэл»-ийн онол юм. Мөн Леви-Строссоос өмнөх домгийн харьцуулсан онолын төлөөлөгч бол Жорж Дюмезиль юм. Леви-Строссын домгийн бүтэц шинжлэлийн аргаар судалсан гол бүтээл нь 1964-1971 онд зохиогдсон «Домгууд» хэмээх зохиол юм. Леви-Строссын хувьд домог нь аливаа эсрэгцэл, зөрчлийг зуучлагчийн тусламжтайгаар шийдвэрлэх логик арга, логик ухамсаргүй үйлдлийн талбар юм. Түүний тайлбараар «домог» бол эх хэлэн дээр тогтдог онцгой хэл байдалтай, нийлмэл зохион байгуулалттай тэмдгийн тогтолцоо мөн. Домгийн тухай К.Леви-Строссын үзэл нь энэхүү нэгэн төрөл хэлийг логик түвшинд хүрээгүй сул хөгжилтэй сэтгэхүйн бүтээл мөн гэж үзсэн францын угсаатны зүйч Л.Леви-Брюлийн үзлийг шүүмжлэх замаар үүсчээ. К.Леви-Строссын үзлээр домгийн логик, орчин үеийн сэтгэхүйн логик хоёр зарчмын хувьд адилхан үнэ цэнэтэй. Өөрөөр хэлбэл, бүр шинэ чулуун зэвсгийн үе хүртэл хамаарах сэтгэхүйн үйл ажиллагааны чухал чухал онцлог бол уламжлалт нийгмүүдийн оюуны төрхөд хадгалагдан байсан төдийгүй орчин үеийн

сэтгэхүйн эд эсэд шинжлэх ухааны сэтгэхүйн хэлбэрүүдтэй зэрэгцдэг гэж К.Леви-Стросс үзжээ. Мөн Леви-Строссын домгийн бүтэц шинжлэлийн онол нь өмнөх онол концепцуудаас, ялангуяа Э.Кассирерын бэлгэдлийн онолоос нэлээд ялгаатай байдлаар домгийг авч үзсэн байдаг. Тухайлбал, Э.Кассирер домгийг бэлгэ тэмдгийн хаалттай тогтолцоо, соёлын элементүүдийн нэг гэж үздэг бол харин К.Леви-Стросс домгийг соёлын амин сүнс, эхлэл, эрчимт хүч, зуучлагч, хөдөлгөөн, хөгжил, өөрчлөлтийн динамик нээлттэй тогтолцоо юм гэж үздэг.

Уран зохиол ба домгийн харилцаа холбооны талаарх үзэл XX зууны 50-иад оны үеэр уран зохиол шүүмжлэгчдийн дунд тархаж эхэлсэн байдаг. Тухайлбал, Ричард Чейз «Домгийн эрэлд» (1949) хэмээх бүтээлдээ домог ба уран зохиолыг ойртуулснаар домгийг уран сайхан, гоо зүйн үзэгдэл байдлаар тайлбарлажээ.

Харин Фрай шог зохиолыг хаврын домог, баатарлаг туужийг зуны домог, эмгэнэлт жүжгийг намрын домог, харин уран элэглэлийг өвлийн домог гэж нэрлэсэн байна.

Домгийн онтологи буюу ахуй, мөн чанарын асуудлыг нэлээд ул суурьтай хөндөж тавьсан сэтгэгч, эрдэмтэн бол XX зууны Оросын хэл шинжээч, философич А.Ф.Лосев юм. Домог бол анхнаасаа ахуйд хандах, рефлексивээс өмнөх хариу үйлдэл юм. Хэл өөрөө мэдлэгийн хэлбэр. Домог бол нэр ба дүрийн нэгдэл. Дүр бол салангид хаос сансрын нэгдэл юм. Домог бол нэг талаас нэр бөгөөд нэр бол ертөнцийг бүтээгч юм. А.Ф.Лосевын үзлээр домог бол **ертөнцийн зөрчилгүй дүр зураг** юм. Домог бол амьдралд өөрт нь байх амьдралын тусгал. Домог бол гайхамшигийн тухай тасралтгүй мөрөөдөл юм.

А.Ф.Лосев «Домгийн диалектик» хэмээх бүтээлийнхээ өмнөх үгэнд «...Бид домгийг яг байгаагаар нь авч үзэж байна, өөрөөр хэлбэл, домог нь өөрөө өөрөөрөө яг юу болохыг, тэр өөрөө өөрийнхөө гайхамшигт үлгэрийн мөн чанарыг хэрхэн сэтгэдгийг гаргаж тавих, эерэгээр шүүн тунгаахыг хүсэж байна...»<sup>6</sup> гэсэн байна. Мөн тэрээр бидний амьдарч буй, бүх юмс оршиж буй ертөнц бол домгийн ертөнц юм, энэ хорвоо дээр зөвхөн домог л байдаг гэж төсөөлсөн цагт домог гэдэг энэ зүйл байдгийг нээх болно гэсэн байна.

А.Ф.Лосевын үзлээр **домог бол зохиомол, хуурамч, уран сэтгэмжит зүйл бус**. Домгийг уран сэтгэмжийн зохиомол зүйл хэмээн үзэх нь ихэнхдээ шинжлэх ухааны үзэл байдаг. Гэхдээ хэрэв домгийн үзлийн өөрийнх нь байр сууринаас авч үзвэл домог бол хэзээ ч хуурмаг, зохиомол зүйл бус. Домогт ямар ч тохиолдлын, хэрэггүй, зохиомол эсвэл уран сэтгэмжийн гэхээр зүйл байхгүй. Энэ бол жинхэнэ, маш тодорхой бодит байдал юм. Домог бол зохиомол бодол бус, харин хамгийн тодорхой, хатуу чанд бүтэцтэй, өөрөөр хэлбэл, ухамсар ба ахуйн диалектикч шинжтэй, зайлшгүй категори юм. Домог бол **санаалаг төгс ахуй бус**. Домог бол цэвэр санааны бүтээл эсвэл юм бус. Цэвэр хийсвэр сэтгэлгээ домгийг бүтээхэд хамгийн бага хэмжээгээр оролцдог. Домгийн ухамсар бол хувь, санаалаг сэтгэхүй биш юм. Харин илүү эрчимтэй, бараг сэтгэл хөөрлийн шинжтэй, ид шидтэй хил залгасан ухамсар юм.

**Домог бол шинжлэх ухааны, тэр дундаа шинжлэх ухааны энгийн байгууламж бус**. Шинжлэх ухаан нь домгоос төрөөгүй, харин шинжлэх ухаан нь өөрөө домгийн шинжтэй. Тухайлбал, Ньютон физикийн механик хуулиа нэг төрлийн төгсгөлгүй, хязгааргүй, өөрөөр хэлбэл, хэлбэргүй орон зайд нээсэн. Лосев Ньютоны механикийг нигилист домогт үндэслэдэг гэж үзжээ. Ньютоны энэ үзэл нь мөн нийгэм, түүхийн төгсгөлгүй хөгжлийн тухай Шинэ Европын үзэлтэй ойролцоо юм гэж Лосев үзсэн байна. Шинэ Европын олон эрдэмтэд нэг үе нь нөгөө үеэ бэлтгэж байдаг гэж үздэг. Үр дүнд нь ямар ч үе бие даасан утгыг агуулдаггүй, бусад бүх үеийн адилаар төгсгөлгүй цагийн аясаар явна гэсэн үг. Үүнийг нийгмийн нигилист буюу үгүйсгэх домог зүй гэж нэрлэж болно хэмээн тэрээр үзжээ. Иймээс шинжлэх ухаан домгоос төрдөггүй, гэвч шинжлэх ухаан нь домоггүйгээр оршин тогтнох боломжгүй, шинжлэх ухаан өөрөө домгийн шинжтэй. Гэхдээ цэвэр шинжлэх ухаан нь өөрөө өөрөөрөө домогт ямар ч хамааралгүй. Харин жинхэнэ бодит шинжлэх ухаан л домгийн шинжтэй байдаг. **Шинжлэх**

6. А.Ф.Лосев. Диалектика мифа. Изд. Мысль. М., 2001. С.33

ухаан аль ч талаасаа шидгүй байх боломжгүй. Харин шинжлэх ухаан домгоос ямар нэг бодворт шинжтэй, логиктой, тооны төлөвлөгөөг гаргаж ирж байдаг. Домог нь шинжлэх ухааны туршлага дээр үндэслэдэггүй. Домгийн ухамсар нь ямар нэг ховор, өмнө нь байгаагүй, сонин, нэг л тохиолдох үзэгдэл дээр анхаарлаа хандуулдаг. Домог нь эдгээрийн учир шалтгааныг тайлбарладаггүй, харин тэднийг ямар нэг яруу тод, уран тод зураглалаар дүрсэлж байдаг. Домог бол ахуй өөрөө, бодит байдал өөрөө, ахуйн тодорхой чанар өөрөө юм. Ямар ч домог зохиогчийг нь зааж өгөөгүй ч байсан үргэлж ямар нэг субъект байдаг. Домог нь үргэлж амьд, үйлдэгч хувь шинжтэй байдаг. Мөн тэр объектив шинжтэй. Харин цэвэр шинжлэх ухааны байр суурь нь объект, субъектээс гадна байдаг. Домог бол таамаглалт бус, гэхдээ баримтат бодит байдал; үйлдэл бус, гэхдээ үр дүн бөгөөд юм; боломж бус, тодорхой мэдрэгдэм, бүтээгдсэн, оршиж буй бодит байдал юм. Домогт онцгой үнэн байдаг. Энд Лосев Кассирерын домгийн тухай символик ойлголтыг шүүмжилсэн байна. Кассирерын үзлээр домогт «бодит байдал» ба «төсөөлөл»-ийн, «чухал» ба «чухал бус»-ын ялгаа байхгүй. Харин Лосевын үзлээр домог нь сэтгэгдлээс үнэнийг, төсөөллөөс бодит байдлыг ялгадаг бөгөөд ялгаж ч чаддаг. Гэхдээ энэ нь шинжлэх ухааны аргаар бус, цэвэр домгийн аргаар боломжтой юм. Эцэст нь домог бол субъект-объектын амьд харилцаа бөгөөд өөрийн шинжлэх ухааны бус, цэвэр домгийн шинжтэй үнэн, лавтай чанар, хууль зүй тогтол ба бүтэцтэй байдаг.

Домог бол метафизик байгууламж бус. Хэрэв метафизикийг энгийн мэдрэмжээс үл хамаарах ертөнцийн тухай, түүний мэдрэмжтэй хэрхэн холбоотой тухай натуралист сургаал гэж ойлговол домог бол ерөөсөө метафизик бус. Лосев домгийг мистицизм, эзотерик, шашинтай адилтгах нь орчин үед ихээхэн төөрөгдөл авчирч байгааг онцолсон байна. Домгийн ухамсрын хувьд домог бол ерөөсөө үлгэрийн ахуй бус, трансцендент ахуй бус. Энэ бол хамгийн бодитой, амьд, дам бус, мэдрэмжтэй ахуй юм. Метафизик бол шинжлэх ухаан байх гэж эрмэлздэг, «мэдрэмжээс ангид» байх чанарын тухай, түүний мэдрэмжтэй харилцах харилцахуйн тухай сургаал байдаг бол домог бол шинжлэх ухаан бус, харин хүрээлэн буй хорвоо ертөнцөд хандах харилцаа юм. Домгийн сэтгэлгээ ердийн юмс ба хүнтэй харилцдаг. Домог бол шинжлэх ухаан, философи биш. Харин философийн зарим концепц домогт илэрч болно. Тиймээс домог бол метафизик байгууламж бус, бодитой, мэдрэмжтэй бүтээгдсэн бодит байдал бөгөөд ердийн үзэгдлээс тусгаарлагдсан; ангижрал, шатлалын янз бүрийн түвшинг агуулж байдаг юм. Домог бол бүдүүвч, ёгтлол бус, харин бэлгэ тэмдэг юм. Домог нь ямагт механизмын тухай бус, организмыг, бүр цаашилбал хувь, амьд бодьгалийн тухай өгүүлдэг. Аливаа бүдүүвч нь механизмыг илтгэдэг. Харин домогт «гадаад», «тодорхой», «мэдрэмжит», «хэсгийн», «бодит», «дүрт» зэрэг шинжүүд чухал байдаг. Тиймээс домог нь схем буюу бүдүүвч биш юм. Ёгтлол ч мөн адил ямар нэг дотоод шинжийг заасан гадаад илэрхийлэл бөгөөд гэхдээ ямар нэг санааг илтгэж байдаг. Гадаад дотоод хүрээнд ямар нэг ялгаатай санаа үүсч байгаа бол энэ санаа нь илэрхийлэгдэшгүй байж таарна. Иймээс бид энэ илэрхийлэх боломжгүй санааг багтаасан «дүр»-ийг сонгож авдаг. Энэ бол ёгтлол юм. Яруу найргийн ёгтлолын сонгодог жишээ бол цамхаг байдаг. Домгийн бодит байдал нь зүйрлэл, ёгт хэллэгийн бус, харин биеэ даасан жинхэнэ бодит байдал юм. Харин ёгтлол бол тэмдэглэгч ба тэмдэглэгдэгчийн хоорондын тэнцүү бус чанар юм. Ёгтлолд дүр нь санаанаасаа ямагт илүү байдаг. Тиймээс домог бол ёгтлол бус. Илэрхийллийн бас нэг хэлбэр бол бэлгэ тэмдэг юм. Бэлгэ тэмдэгт дотоод ба гадаад, санаа ба дүр, санаалаг ба бодит байдлын хооронд ялгаа байхгүй. Бэлгэ тэмдэг нь биеэ даасан бодит байдал юм. Хэдийгээр энэ нь ахуйн хоёр өөр төрлийг багтаадаг ч гэсэн энд үнэмлэхүй ялгамж ноёрхдог бөгөөд хаана «санаа», хаана «юм» байгааг хэлж болохгүй. Энэ нь мэдээж хэрэг бэлгэ тэмдэгт «дүр» ба «санаа» ялгардаггүй гэсэн үг биш. Бэлгэ тэмдэгт ч мөн адил ёгтлол, зүйрлэлийн адилаар «гадаад» ба «дотоод»-ын адилтгал байдаг ч бэлгэ тэмдэг нь адилтгалд өөрт нь биш, харин яг «юу» «юу»-тай адилсаж байгаа, ямар «санаа» ямар «үзэгдэл»-тэй адилсаж байгаад оршдог. Учир нь «дотоод», «гадаад» аль аль нь өөрсдөө мөн олон давхарга бүхий «дотоод»,

«гадаад»-ыг багтаадаг. Жишээ нь геометрийн дүрс нь хийсвэр тоотой харьцуулахад илүү «тодорхой», «гадаад» шинжтэй. Харин мод эсвэл металаар хийсэн аливаа дугуй юм (машинны дутуй гэх мэт) нь геометрийн дүрсийг бодвол мөн л илүү тодорхой, гадаад шинжтэй гэх мэт. Ахуйд утга санаа ба үзэгдэл гэсэн хоёр давхарга байдаг. Тэдгээрт мөн адил өөр өөрийн утга санаа, үзэгдэл гэсэн давхарга байгаа. Энэ хоёр давхарга нь бие биетэйгээ адилсан нэгдэлд орно. Мөн давхаргын дэд давхаргууд адилсан нэгдэлд орно гэх мэтээр үргэлжилнэ. Бэлгэ тэмдэг нь санаа ба юмсын зөвхөн утгын бус, бүр бодит адилтгал юм. Механизм, ёгтлол, бэлгэ тэмдгийн ялгааг жишээн дээр тайлбарлавал илүү тодорхой байх болно. Жишээлбэл, Лосевын үзлээр урлаг бол амьдралтай харьцуулахад илүү аллегорич буюу ёгтлол шинжтэй. Гэхдээ урлаг өөрөөрөө бол бэлгэ тэмдэг байдаг, байх ч ёстой. Харин амьдралтай харьцуулахад л урлаг ёгтлол шинжтэй. Амьдрал бол өөр өөртөйгөө л ямагт адил байдаг. Домгийн бэлгэ тэмдгийн давхаргууд нь маш нарийн. Тухайлбал, ертөнцийн үүслийн тухай домогт гол баатар нь ертөнц өөрөө эсвэл, байгалийн хүч, анхдагч зарчим байдаг. Энэ утгаар домог бол хэзээ ч адилтгал, зүйрлэл, бүдүүвч биш, харин юуны өмнө бэлгэ тэмдэг юм. Домог нь нэгэн зэрэг бүдүүвч, адилтгал, зүйрлэл, эсвэл бэлгэ тэмдгийн давхаргуудтай байдаг. Домог бол яруу найргийн бүтээл биш. Юуны өмнө домог ба яруу найргийн төсөөтэй талыг авч үзье. Яруу найраг бол үргэлж үг байдаг. Үг бол ямагт ямар нэг зүйлийг илэрхийлж байдаг. Үг бол зүгээр нэг юм эсвэл утгатай төдий бус, ямагт илэрхийлэл, бас ойлгохуй байдаг. Үг бол гүехэн бус, гүн рүү чиглэсэн байдаг. Тэгвэл домог ч мөн адил юм. Харин домгийн үгэн шинж нь далд мэт боловч илэрхий байдаг. Домогт үргэлж хоёр буюу түүнээс дээш давхарга байх бөгөөд эдгээр нь бие биетэйгээ адилсаж, нэгийг нь нөгөөгөөр нь таньж болдог. Мөн яруу найраг ба домог нь хоёулаа оюунлаг шинжтэй. Яруу найраг нь зүгээр нэг илэрхийлэл төдий бус, харин үргэлж амьд, эрх чөлөөтөй байхыг хүсдэг; амьд бус харанхуй, дүлий, мухар зүйлсээс чөлөөлөгдөхийг хүсдэг. Домог ч мөн адил хэдийгээр амьгүй зүйлсийн тухай өгүүлж байсан ч эхнээсээ амьд байсан л гэж үздэг. Яруу найргийн анхаарал хандуулж буй тэр зүйл нь яруу бус, харин түүнийг ойлгох, бүтээх арга зам нь л яруу байдаг. Домог ч мөн үүний адил юм. Гэхдээ домогт ч, яруу найрагт ч бүх зүйл амьтай байх албагүй. Домгоор амьдарч мэдэрч байгаа хүмүүс амьтай болон амьгүй зүйлсийг гайхалтай ялгах чадвартай байдаг. Мөн яруу найраг, домог зүйн дүрд ямар ч логик, шинжлэх ухаан, философи, ерөөсөө ямар ч онол хэрэггүй. Дүр нь шууд, ил тод харагддаг. Мөн яруу найраг, домог нь хоёулаа ямар нэг байдлаар тусгаар шинжтэй. Өөрөөр хэлбэл, эдгээр нь ямагт өдөр тутмын, ердийн зүйлсээс ямар нэг байдлаар тусгаар, бараг ер бусын гайхамшигтай гэмээр байдаг. Яруу найргийн тусгаар шинж нь баримтаас тусгаарлагдсан шинж юм. Харин домгийн тусгаар шинж нь өдөр тутмын амьдралын утга санаанаас тусгаарлагдсан шинж юм. Домгийн тусгаарлагдсан байдлын цорын ганц хэлбэр бол юмсын утга санаанаас тусгаарлагдсан байдал юм. Домгийн юмс нь баримтат шинжээрээ хэвээр үлдэж харин түүний утга санаа нь өөрчлөгддөг. Жишээ нь хивс бол өдөр тутмын амьдралын жирийн л зүйл. Харин нисдэг хивс бол шидэт домгийн нэг дүр. Энгийн хивс болон нисдэг хивс хоёрын ялгаа нь баримтанд бус, харин утга санаандаа л байгаа юм. Оршихуйгаараа бодит байдал нь домогт ч, өдөр тутмын амьдралд ч адил бөгөөд харин түүний утга санаа нь л өөрчлөгддөг. Харин яруу найрагт үйлдэл, мэдрэмжийн бодит байдал үгүй болдог. Жишээлбэл, театрын тоглолт үзэхдээ бид бусдын байр сууринаас ханддаг. Яруу найргийн бодит байдал нь эргэцүүллийн бодит байдал байдаг бол харин домгийн бодит байдал нь бодитой, биет, бүр цаашилбал мэдрэмжтэй бодит байдал байдаг. Яруу найраг бол домог биш юм. Яруу найраг ямар нэг ер бусын онцгой дүр төрхийг өгөх албагүй. Пушкины Борис Годунов болон Евгений Онегин эргэлзээгүй найраг зүйн дүр; эдгээрт ямар ч ер бусын, хачин, домгийн утгаараа тусгаарлагдсан шинж байхгүй. Тиймээс яруу найраг нь домоггүйгээр байх боломжтой. Үүнтэй адилаар домог ч гэсэн яруу найраггүйгээр байх боломжтой юм. Лосевын тодорхойлсноор домог бол хувь ахуй эсвэл хувь ахуйн дүр, хувь хэлбэр, хувь дүр царай юм. Хувь чанар гэдэг бол юуны өмнө өөрийн ухамсар, интеллигенц

(сэхээрэл) юм. Хувь чанар бол ямагт илэрхийлэл байдаг учраас бэлгэ тэмдэг юм. Энэ утгаараа домог бол бэлгэ тэмдэг (символ) юм.

**Домог бол ямар нэг тусгай шашины бүтээл бус юм.** Лосев домог ба шашины ялгаатай ба төсөөтөй чанарыг гаргаж тавьсан байна. Үүнд, домог ба шашин нь хоёулаа хувь ахуйн хүрээ юм. Шашинд хувь хүн зөвтгөл, аврал, өршөөл нигүүлсэл, ариусгалыг эрж хайж байдаг. Домогт хувь хүн илэрч, өөрийгөө илэрхийлж, ямар нэг өөрийн түүхтэй байхыг эрмэлздэг. Харин ямар ч шашин хувь бодгалийг мөнхийн ахуйд багтахыг, үргэлж үнэмлэхүй ахуйтай холбоотой байлгахыг хичээдэг. Харин домог бол мөн субстанциаль шинж бүхий илэрхийлэл бус, мөнхийг багтах баталгаа бус, харин эргэлзээгүй хувь бодгаль эхлэлтэй байдаг юм. **Домог мөн чанараараа, цэвэр байдлаараа хэзээ ч, зарчмын хувьд шашины шинжтэй байдаггүй.** Шашин бол үргэлж үйлийн үр, ариусал, аврал, нүгэл, зөвтгөл зэргээр оршдог. Харин домог эдгээр асуултгүйгээр оршин тогтнож чаддаг. Шашин бол домогт зөвхөн ямар нэг тусгаар агуулгыг л өгдөг, иймээс л шашины шинжтэй домог байдаг, харин домгийн өөрийнх нь бүтэц бол шашины болон бусад ямар нэг агуулгаас үл шалтгаалдаг. Домог бол хувь бодгалийн субстанциал бус, харин эрч хүчний үндэс юм. Энэ бол хувь бодгалийн хамгийн гүн гүнзгий үндэс бус, харин түүний илэрдэг, үзүүлдэг үйл ажиллагаа байдаг. Энэ бол субстанц бус, харин хувь бодгалийн дүр, зураглал, утгат үзэгдэл юм. Энэ бол хувь бодгалийн нүүр царай (лик) юм. Домог бол хувь бодгалийн дүр, зураглалт туяарал бөгөөд хэзээ хуар бүхий эрээлсэн зураглал юм. Домог бол хувь бодгаль өөрөө биш, харин түүний нүүр царай; иймээс нүүр царай бол хувь бодгалиас тусдаа бус, тиймээс домог нь хувь бодгалиас тусдаа биш. Домгийн нүүр царай нь тусдаа бус, учир нь энэ нь өөрөө хувь бодгаль юм. Харин хувь бодгаль нь нүүр царайнаасаа ялгаатай, учир нь хувь бодгаль нь өөрийнхөө нүүр царай бус. Шашингүй домог байх боломжтой, гэхдээ домоггүй шашин байх боломжгүй юм. Домог бол шашнаас өргөн утгатай. Шашин бол тусгай домог, амьдралын домог, бүр тодруулбал, домог мэт амьдрал юм. Домоггүй шашин бол хувь бодгалийн үүрэг, илрэл, илэрхийлэлгүй хувь санаа байх байсан юм. Ийнхүү домог бол шашины зориудын бүтээл эсвэл шашины хэлбэр бус, өөрөөр хэлбэл хувь бодгалийн өөрийгөө мөнх байлгах гэсэн субстанциональ санал бус, харин мөнх ба цаг хугацаа хоорондын харилцааны асуудлаас үл хамаарах эрч хүчтэй, феноменаль эхлэл юм.

**Домог бол ягшсан номлол, тогтсон таалал (догма) бус.** Учир нь ягшсан номлол бол ямар нэг байдлаар шашины туршлага болон шашины домгийн рефлекс (тусгал) байдаг. Харин домог нь ямар ч тусгал бус. Домог нь үргэлж ямар нэг үзэгдэх чанар, шууд энгийн бодит байдал, амьдралын харагдахуйц, тэмтрэгдэхүйц зүйл юм. Ягшсан номлол бол зөвхөн тусгалт шинжтэй төдийгүй, бас үнэмлэхүй шинж бүхий үнэлгээ, үнэт зүйл байдаг. Энэ бол ямагт үзэгдлийн биет, цаг хугацаалаг, түүхэн урсгалаас ялгаатай мөнхийн үнэнийг баталж байдаг. Харин үүний эсрэг домог бол баримтат, түүхэн шинжтэй. Ягшсан номлол нь хувь ахуйн түүхэн баримтуудыг үнэмлэхүй болгодог. Домог бол тэр, энэ хувь ахуйн үнэмлэхүй мөн чанараас үл хамаарах түүхчлэл буюу зүгээр л түүх юм. Домог бол түүхээр өгөгдсөн хувь ахуй юм.

**Домог бол түүхэн үйл явдал биш юм.** Түүх бол хоорондоо шалтгаант холбоотой баримтуудын цуглуулга юм. Баримтууд дангаараа дүлий, анир чимээгүй юм. Ойлгогдоогүй баримтууд бол түүх биш юм. Түүх бол ойлгогдсон баримтуудын түүх байдаг. Түүхийн үйл явцыг гурван давхаргад хувааж болно. Нэгдүгээрт, түүхийн байгаль-эд юмсын давхарга. Түүх бол цаг хугацаа, орон зайн бүхий л талын харилцаанд байх, бие биедээ шалтгаан үрийн харилцаагаар нөлөөлж байдаг, ямар нэг баримтуудын нийлбэр юм. Хоёрдугаарт, ухамсар ойлголтын давхарга. Түүх бол ойлголтын баримт, ойлгогдсон баримтуудын цогц учраас ухамсрын модус юм. Домгийн шинжийг агуулдаггүй нэгдүгээр давхаргатай харьцуулахад энэхүү хоёрдугаар давхарга нь домогт баримтан материалыг өгч байдаг, өөрөөр хэлбэл домгийн түүх эргэлдэж байдаг тэрхүү тайз нь юм. Гуравдугаарт, өөрийн ухамсар, эсвэл үгийн давхарга. Түүх бол ямар нэг боломжит эсвэл бодит ухамсрын зүйл, эсвэл ухамсрын бүрэлдэл байхаас гадна, өөрөө

өөрийнхөө төлөө объект, субъект нь болж, өөр юуны ч бус, харин өөрийнхөө ухамсрын юм болдог. Түүх бол бүрэлдэн тогтож буй, төрж, хөгширч улмаар үхэж байдаг өөрийн ухамсар юм. Түүх бол ухамсарлаж илэрхийлсэн баримтуудын бүтээл бөгөөд энд л тусгаар юмс нь хувь ухамсар, ухамсарт оршихуйн илэрхийллээрээ дамжуулж нийтийн үйл хэрэгт оролцдог. Бүтээлч, идэвхтэй илэрхийлэгдсэн хувь ухамсар гэж юу вэ? Энэ бол үг юм. Ухамсар нь үгэнд л хувь ухамсрын түвшинд хүрдэг. Үг бол хувь бодгалийн өөрийн зохион байгуулалтын эрхтэн, хувь бодгалийн түүхэн ахуйн хэлбэр болдог. Түүх нь үггүйгээр дүлий сохор, хэнд ч юу ч ярьдаггүй сайхан зурагдсан зурагтай адил юм. Түүх бол баримтуудын дүр зураг төдий бус, бас үг байх ёстой. Домгийн ухамсар нь түүхэн баримтуудын тухай үг, хувь бодгалийн амьдралын тухай өгүүлэмжийг өгч байх ёстой. Домог бол цэвэр түүхэн үйл явдал бус, гэвч энэ нь үргэлж үг байдаг. Домог бол үгэнд өгөгдсөн, хувь шинжтэй түүх юм.

А.Ф.Лосев ийнхүү домгийн мөн чанарыг гаргаж ирэхийн тулд домог нь юу биш вэ гэдгийг гаргаж тавиад улмаар юу болохыг тодруулсан байна. Түүний үзлээр домог бол гайхамшиг юм. Гайхамшиг бол бэлгэ тэмдэг юм. Домог бол үгэнд өгөгдсөн, хувь бодгалийн, гайхамшигт түүх юм. Домог бол хувь хүнд өөрт нь, түүнд л зориулагдсан, түүнээс салшгүй тийм үг байдаг. Хувь бодгаль бол дахин давтагдашгүй цорын ганц юм. Тиймээс хувь бодгалийн үг ч гэсэн цорын ганц, хувь хүний өөрийнх нь үг ба хувь хүний тухай өөрийн үг юм. Энэ бол нэр юм. Нэр бол хувь хүний өөрийнх нь үг юм, зөвхөн тэр л ганцаараа өгч чадах, өөрийнхөө тухай илэрхийлж чадах тийм үг юм. Домог бол гайхамшигийг бүтээдэг, урвуу харсан шидэт үг юм. Өөрөөр хэлбэл, Лосевын үзлээр домог бол жинхэнэ бодит байдал боловч урвуу харсан, бүтээгч идэвхтэй эхлэл юм.

Ер нь домог нь соёлын бусад элементтэй, тухайлбал философи, шашин, шинжлэх ухаан зэрэгтэй ямар холбоо харилцаанд байдаг вэ гэдэг нь домгийн ахуй, мөн чанарын асуудал, судалгаанд ихээхэн чухал юм.

Философи, домгийн харилцаа холбооны талаар яриа үүсэхэд философийн үүслийн асуудал хөндөгддөг. Философийн үүслийн судлагдахуунд хоёр үндсэн арга зүйн хандлага байдаг. Үүнд, философи нь домгоос үүсэлтэй, эсвэл философи нь гносиоген буюу танин мэдэхүйгээс үүсэлтэй гэсэн хандлага багтах юм. Эдгээр хандлага нь хоёулаа философийн үүслийг ямар нэг түүхэн шугаман үйл явцын талаас нь авч үздэг. Өөрөөр хэлбэл, философи нь түүнээс өмнө байсан ухамсрын ямар нэг хэлбэрээс үүсэлтэй гэсэн үг. Гэхдээ энэ хоёр тохиолдолд философийн үүслийн үйл явцыг «домгоос үг ойлголт»-руу шилжихтэй холбож тайлбарладаг. Философийг домгоос үүсэлтэй гэсэн хандлага нь философи нь домгоос шидэт домгийг хөгжүүлж үүссэн тухай бөгөөд харин философийг танин мэдэхүйгээс үүсэлтэй гэх хандлага нь философи нь домгоос ангижирч үүссэн тухай юм. «Логос буюу үг» гэдэг нь ухамсрын эртний хэлбэрийн хөгжлийн үр дүн бөгөөд энэ бол санааг бүтээх сэтгэлгээ, ойлголтоор илэрхийлэгдэх, эргэцүүлэх чадвар бүхий судлагдахуунт сэтгэлгээ юм.

Мифоген, гносиоген хандлагын ялгаа нь анхны философичид өөрийн санааг олж байсан тэр түүхий эдийг яаж ойлгох вэ гэдэгт оршино. Танин мэдэхүйгээс эхлэлтэй гэх хандлага нь философийг шинжлэх ухаантай бүрэн адилтгадаг бөгөөд соён гэгээрүүлэгч рационалист үзэл юм. Позитивистууд ихэнхдээ энэ хандлагыг баримталдаг бөгөөд философийг онолын байгаль шинжлэл гэж үздэг. Энэ хандлагын үүднээс философи нь домгоос бус харин туршлагын мэдлэгээс үүсэлтэй бөгөөд энэ нь эхлээд домгийн хүрээнд хуримтлагдаж дараа нь домогтой зөрчилдөж, эцсийн эцэст түүнээс чөлөөлөгдөж жинхэнэ философи болсон ба ертөнцийг танин мэдэхүйн энгийн хэлбэр болох домгийг ялж гарч ирсэн байна. Өөрөөр хэлбэл, натурфилософичид байгалийн үзэгдлийг бурхдын үйл ажиллагааны үүднээс бус байгалийн хүчнүүдийн үүднээс тайлбарлаж эхэлсэн тэр цагаас философи үүсчээ.

Философийг танин мэдэхүйгээс үүсэлтэй гэх хандлагын дутагдалтай тал нь философийн үүслийн гол гогцоог тайлж чадаагүйд, туршлагаас үүссэн философийн танин мэдэхүйн шинжийг

тайлбарлаж чадаагүйд, хэрэглээний мэдлэгээс хэрхэн яаж ерөнхий онол үүсэхийг бүрэн гүйцэд тайлбарлаж чадаагүйд тус тус оршино. Үнэн хэрэгтээ туршлага, философи хоёрын хооронд ямар шууд хамаарал байна вэ? Шинжлэх ухаанаас өмнөх мэдлэгээс философи руу шилжих шалтгаан үрийн холбоо байна уу? Хэрэв шинжлэх ухааныг Европын утгаар ойлговол зөвхөн философи л туршлагаас олж авсан мэдлэгийг дахин нягталж, хэрэглээний мэдлэгээс шинжлэх ухааныг үүсгэж чадна. Философи бол шинжлэх ухааны үүслийн гол хүчин зүйл юм. Ингэж үзвэл философийг танин мэдэхүйгээс үүсэлтэй гэх хандлага нь эртний үеийг шинжлэх ухааны позитивизмын үүднээс шууд эдүгээчилж байгаа хэрэг юм. Оросын философич М.И.Шахнович «Эртний домог зүй ба философи. Философийн өмнөх түүх» хэмээх бүтээлдээ «...Философи нь оюунлаг хөдөлмөр биеийн хөдөлмөрөөс салсны дараа, ертөнцийн тухай туршлагат мэдлэг хөгжсөний дараа үүсдэг...» гэсэн байна. Энэ бол философийн үүслийн гносиоген буюу танин мэдэхүйн хандлагын жишээ юм.

Харин философийг домгоос үүсэлтэй гэх хандлага нь **философи бол домгийн хамгийн дээд түвшин гэж үздэг**. Энд философийг «домгийн логос буюу үг», «рефлексийн толинд байх домог», «домгийн ертөнцийг ойлгох үзэл» гэх мэтээр үздэг. Энэ хандлагаар бол натурфилософичид хийсвэр хэлээр Гесиодыг илэрхийлж, «Теогон»-оос онол бүтээж эхлэх үед философи үүссэн байна. Домог ба философи нь мөн чанараараа холбоотой, учир нь эдгээр нь оршин ахуй болон хүний хоорондын харилцааг авч үздэг. Гэхдээ философийг домгоос үүсэлтэй гэх хандлагад ч гэсэн дутагдал байгаа бөгөөд энд философи нь шинэлэг зүйл байхаа больж, харин домог нь эхнээсээ философидолт байсан мэт болж байна.

Философийг танин мэдэхүйгээс эсвэл домгоос үүсэлтэй гэх онол, хандлагын хооронд нэг нийтлэг зүйл байгаа юм. Энэ нь сэтгэлгээний үүслийн тухай асуудалтай холбоотой. Үүнээс философийн үүсэл нь сэтгэлгээ бус, харин түүний агуулга, судлагдахуунтай холбоотой бөгөөд харин философи нь өөрөө ертөнцийг үзэх үзэл гэж ойлгогдож байна.

М.Хайдегер «Метафизикийн үндсэн ойлголтууд» хэмээх цуврал лекцэндээ философи нь зөвхөн «өөрөөрөө дамжуулж, ямар нэг зүйлтэй харьцуулахгүйгээр зөвхөн өөртөө» -л ойлгомжтой байж болдог гэсэн байна. Түүнийг ямар нэг өөр ойлголтын тусламжтайгаар тодорхойлох боломжгүй, түүнийг шинжлэх ухаан эсвэл ертөнцийг үзэх үзэл гэж үзэх нь түүний мөн чанарыг огт мартсантай адил юм. Философи бол философидолт юм. Өөрөөр хэлбэл, философи бол судлагдахуунт мэдлэгийн цуглуулга бус, харин сэтгэлгээний амьд үйл явц бөгөөд бид энэ үйл явцаар бүрэн эзэмдүүлсэн тохиолдолд л тэр байх боломжтой. Эзэмдүүлсэн гэдэг нь юу гэсэн үг вэ? Хүн онцгой сэтгэл санаанд эзэмдүүлсэн үед л философддог бөгөөд энэ сэтгэл санаа нь мөн чанараараа үйл явц бөгөөд энэ утгаараа биднээс хамааралгүй, биднийг бүрэн эзэмддэг. Философидох энэхүү суурь сэтгэл санаа нь «хаана ч гэртээ байх гэсэн эрмэлзэл, эргэн санахуй» байдаг. Хайдегер романтик яруу найрагч Новалисаас энэ санааг авсан гэдгээ зохиолдоо өгүүлсэн байна. Мөн Хайдегер философидолтын мөн чанарыг «философидож буй бид хаана ч гэртээ биш байх үед л философи нь ийм эрмэлзэл байж чаддаг. Энэ эрмэлзэлийн эргэн санахуй нь яагаад санагалздаг вэ? Хаана ч гэртээ байх гэдэг нь юу гэсэн үг вэ? Хаана ч гэртээ байх гэдэг нь бүх газар, тэнд энд байх гэдгээс гадна үргэлж, хамгийн гол нь бүхэлтэг байхыг хэлнэ. Энэ бүхэлтэг байх, бүхэл гэдэг нь ертөнц юм» гэх тайлбарлажээ. Ийнхүү сэтгэлгээ нь бүхэл рүү тэмүүлэх тэмүүлэл, ертөнцийг санагалзах санагалзахуй хүнийг эзэмдэх үед эхэлдэг. Философидолт нь ертөнцийг гэртээ байгаа мэт мэдрэх мэдрэмж дутсанаас, эргээд гэрлүүгээ буцах шаардлагаас урган гардаг. Хэрэв философи нь эргэн санагалзахуй юм бол шидэт домог нь гэртээ тухтай байхуй юм. Ийнхүү философийн үүсэл нь шидэт домгийн хямралтай холбоотой юм. Учир нь философидолт бол бүхэл ертөнц, гэр ертөнц (шидэт домгийн үндсэн шинж) алдагдах үед л боломжтой юм.

Философи бол шидэт домгоос шууд урган гараагүй, харин шидэт домог нь гүнзгий хямралд орсон үед л боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл, философи ба шидэт домгийн хооронд

ямар нэг хил хязгаар хоосон зай байхгүй гэсэн үг юм. Энэ хоёр бол нэг юмны хоёр тал юм. Шидэт домог байхгүй бол философи байхгүй, философи байхгүй бол шидэт домог байхгүй. Философи нь ямар ч судлагдахуунгүй хэл бий болсон цагт үүссэн. Хүн төрөлхтний ямар ч хэл судлагдахуунтай. Үг болгонд референ<sup>7</sup> байдаг. Оросын философич М.К.Мамардашвили «Харин философи бол арай өөр юм. Хэлний энгийн нөөц боломжийг ашиглахдаа философи нь эхнээсээ л ямар нэг өөр зүйлийг хэлэхийг л эрмэлзсэн юм» гэсэн байна.

Орчин үеийн философид домгийн сэтгэлгээг зөвхөн эртний хүмүүсийн, балар цагийн сэтгэлгээ хэмээн үзэхээс улам бүр татгалзсаар байна. Байгалтай нэгдмэл гэдэг мэлрэмж нь домгийн сэтгэлгээний хамгийн гүн гүнзгий, хүчтэй түлхэгч хүч нь юм. Домгийг ямар нэг худал хуурмаг эсвэл цэвэр төөрөгдөл гэж үзэх ямар ч үндэслэл байхгүй болжээ. Домог бол бодит байдлын хийсвэр танин мэдэхүйн хэлбэрүүдээс хүний оршихуйн үндэст хамгийн ойр байдаг гэсэн таамаглалуудыг дэвшүүлдэг. Орчин үеийн философичид домгийг бодит үйл явдлын нууц түлхүүрээр бичсэн хүүрнэл гэдэгтэй санал нийлдэг. Олон философич домогт гүн гүнзгий, арилдаггүй, түгээмэл учир холбогдол байгааг олж хардаг болжээ.

### НОМ ЗҮЙ

1. П.С.Гуревич. Философия культуры. М., 2000
2. А.Камю. Бунтующий человек. Философия. Политика. Искусство.- Политиздат, 1990
3. Э.Кассирер. Философия символических форм. Том 2. Мифологическое мышление. М.; СПб.: Университетская книга, 2001
4. К.Леви-Стросс. Структурная антропология. М., 1983
5. А.Ф.Лосев. Диалектика мифа. М., 2001
6. М.К.Мамардашвили. Первобытная мифология и философия. Предыстория философии. Лен. 1971
7. Е.М. Мелетинский. Поэтика мифа. М., 1976
8. М.Хайдегер. Основные понятия метафизики // Вопросы философии 1989 №9
9. М.И.Шахнович. Первобытная мифология и философия. Предыстрия философии. Лен. 1971

### ABSTRACT

*The main issue of our article is the ontological problem of the myth in the modern philosophical thought. We aimed to explain some modern philosophical idea about myth and to give ontological definition of the myth.*

*By the beginning of XX century philosophers, anthropologists, sociologists and ethnographers have been had different ideas from classical philosophical thought about myth. They suggested following ideas about myth: first, myth is the live eternal genesis, which has the practical function in the modern society; second, myth is the ritual and real nature and an eternal regularity; third, myth is the ideology, collective unconsciousness.*

*Myth has practical function in the society. For example, American anthropologist Franz Boas, Scottish anthropologist James George Frazer and British anthropologist Bronislaw Kasper Malinowski emphasize that myth is not belief and doctrine system, but it has more action character than imaginative. They founded ritualism and functionalism in the study of the myth.*

*French sociologists have different ideas about myth from British anthropologists. They emphasize a collective psychological and social interpretation about myth. For instance, David Emilie Durkheim*

7. Референт- тэмдэглүүлэгч

said that religion and myth is not different things, which are both collective imagination, reflecting a social reality. But Durkheim also emphasizes the ritual function of myth. By Lucien Levi Bruhl, the important and valuable thing of the myth is a mysterious element. He confirms that myth is not an explanation of the world, but it is supporting ways and means of the societies group's unity.

Myth is not a primitive thought of ancient period; it is an eternal regulation of the culture and logical solution of fundamental opposition of man's life. German philosopher Ernst Cassirer believes that myth is the cultural autonomous symbolic form, which is the special method and measure of the feeling and sensitive symbolic objectivities. Levi-Strauss has a different idea from the Cassirer's symbolic theory and he said that myth is a dynamic open system of the social changing and intensive power of the culture and reflects anatomy of mind.

According the psychoanalytic philosophers, especially for Freud and Jung myth is the unconscious basis of the human psychics.

Russian philosopher Losev gives an ontological definition of the myth and concluded that myth is the unturned magic name, which produces the wonder. By his idea myth is itself image of the world and most real, instant and sensitive being.

In conclusion we try to definite myth from fundamental ontology of philosophy. Heidegger said that philosophy is the philosophizing. Philosophizing is the wish to be everywhere as at home, missing home and wish being at all. If philosophy is the wish to being at all, myth is the being at all, being at home.

Modern philosophers refuse to consider that myth is the primitive thought from ancient period. Most philosophers agree that the myth lives everywhere, in the past, today and in the future. They agree that feeling united with nature is one of the deepest and powerful motivation of the mythical thought. There is no ground in myth that it is kind of illusion or untrue tale. Among the forms of knowledge about human essence, myth is the closest to the human nature. Modern commentators assume that myth is a narrative which decrypts the reality with mystical key-words. Many philosophers see universal and imperishable attributes or causes in myths.